

УБЕГ-ын 2024 оны санхүүгийн тайланд Үндэсний болон Төрийн Аудитын газраас тавьсан актын биелэлт

2025.06.12-ны байдлаар

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Хууль эрх зүйн үндэслэл	Актын биелэлтийг хэзээ, хаана өгөх	Биелэлт
1	Дархан-уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Акт: Тайлант онд байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг илүү олгосон байна.	7,062,800.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.	Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт ирүүлэх	Актын биелэлтийг Дархан аймгийн Да.Хүү, торгуулийн орлого 100190000988 тоот дансанд 2025.05.26-ны өдөр 7.062.800.00 төгрөгийг шилжүүлсэн
2	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК	Акт: Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-ийн 2 ажилтан 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр эрх барих этгээдийн мэдээлэлд бүртгэгдэж, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон боловч тайлант онд үндсэн ажилтнаар ажиллаж 36.419.9 мянган төгрөгийг цалин давхардуулан авсан байна.	36,419,999.40	Компаний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүний төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэгтэй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж заасныг тус тус зөрчсөн байна..	Актын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх	Хугацаа болоогүй
4	Нийт дүн		43,482,799.40			

УБЕГ-ын 2024 оны санхүүгийн тайланд Үндэсний болон Төрийн Аудитын газраас тавьсан албан шаардлагын биелэлт

2025.06.12-ны байдлаар

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Хууль эрх зүйн үндэслэл	Албан шаардлагын биелэлтийг хэзээ, хаана өгөх	Биелэлт
---	------------------	---------------------------	------------	-------------------------	---	---------

1	Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Цалингийн сангаас урамшуулал олгосон.	3,328,000.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.03.24-ний өдрийн 11/230 тоот албан бичгээр Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
2	Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: УБЕГ-ын даргын 2024.10.11-ний өдрийн Нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмж олгох тухай Б/579 дүгээр тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгох шийдвэрээр цалингийн зардлаас 1,452,0 мянган төгрөгийг олгосон байна.	1,452,000.00	Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.02.27-ны өдрийн 13/213 тоот албан бичгээр Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
		Албан шаардлага: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 1,452,0 мянган төгрөгийн 3 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 26,595,9 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	26,595,900.00	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 дахь" цалингийн зардлаас бусад таваан сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалтыг зөрчсөн байна.		

3	Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Байгууллагын даргын 2024 оны А/18 дугаар тушаалаар цалингийн сангаас нягтлан бодогчид 1 сарын үндсэн цалингаар балансын урамшуулал олгосон байна.	1,471,000.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 25-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 14/392 тоот албан бичгээр Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
4	Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 5.431.5 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	5,431,500.00	Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэ, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал олгоно, 1.2.1-д төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд, 2.2-д Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй" гэж заасныг зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 22/826 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
5	Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Тусгай зориулалтын материалын /үнэт цаас/ 8.959.3 мянган төгрөгийн зарлагын анхан шатны баримт бүрдэл дутуу байна.	8,959,300.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчин иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.28-ны өдрийн 23/300 албан бичгээр Өвөрхангай аймгийн Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

6	Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Өмнөговь аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнагдсан 4 албан хаагчид шагналын дагалдах мөнгөн урамшуулал болох 1.059.200 төгрөгийг цалингийн сангаас олгож, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1,059,200.00	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Өмнөговь аймгийн засаг даргын 2011 оны А/14 дүгээр захирамжаар батлагдсан "Өмнөговь аймгийн Засаг даргаас байгууллага, иргэдийг шагнаж, урамшуулах журам"-ын 3.1-д Өмнөговь аймгийн "Тэргүүний ажилтан хүндэт тэмдэг", "Хүндэт дэвтэр"-т бичих, "Жуух бичиг"-ээр шагнагдсан шагналын дагалдах мөнгөн шагналыг иргэнийг шагнуулахаар санал ирүүлсэн сум, байгууллага хариуцах бөгөөд хэмжээ нь албан тушаалын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцүү байна" гэж заасантай нийцэхгүй байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.03.25-ны өдрийн 24/199 албан бичгээр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
7	Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Албан шаардлага: Тайлант онд багаж, техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 206.4 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна.	206,400.00	Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно" гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор гаргаж Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.06.12-ны өдрийн 26/414 албан бичгээр Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
		Сахилгын хариуцлага тооцох албан шаардлага: Төлбөр тооцоог урьдчилан хянаагүй улмаас нийгмийн даатгалын шимтгэлийг давхардуулан шилжүүлж, 10.557.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	10,557,900.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.		
		Албан шаардлага: Улсын төсвийн орлогод төвлөрүүлдэг үйлчилгээний орлоын буцаалт хийх журам байхгүй, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга хянадаггүй, мөнгө шилжүүлэхэд нэгдүгээр гарын үсэг эзэмшигч буюу газрын дарга цохолт хийдэггүй.	75,272,800.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна.		

8	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	Албан шаардлага: НУБГ-ын хөрөнгийн жилийн эцсийн тооллогын зохион байгуулалт нь нийслэлийн дүүргүүдэд хөрөнгө тарж байрласан онцлогийг тусгаагүй, дүүргүүдийн хөрөнгийн тооллогын дүн мэдээг нэгтгэх, тооллогын тайлбар илтгэл бэлтгэх зэргийг тусгасан тодорхой төлөвлөгөөгүй байсан.	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна" гэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын 2025.04.30-ны өдрийн 10/259 тоот албан бичгээр Ниямазон аудит ХХК-д хүргүүлсэн.
		Албан шаардлага: БЗД-ийн улсын бүртгэлийн хэлтэст УБЕГ-аас НУБГ-аар дамжуулалгүйгээр үнэ төлбөргүй өгсөн цэвэрлэгээний машиныг холбогдох тушаал шийдвэргүйгээр данснаас хассан.	30,000,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараах бүрэн эрхтэй; /төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр шийдвэр гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.		
		Албан шаардлага: Дүүргийн хэлтсүүдэд УБЕГ-аас НУБГ-аар дамжуулалгүйгээр үнэ төлбөргүй өгсөн хангамжийн материалыг тушаал шийдвэргүйгээр данснаас хассан.	7,070,700.00	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.		

9	Улсын бүртгэлийн ерөнхий газар/төв аппарат/	Албан шаардлага: Гадаад харилцааны яамтай үнэт цаас болон сонгуулийн санал хураах тоног төхөөрөмж, иргэний мэдээлэлтэй компьютерийг баланст бүртгэж, ашиглалтад хяналт тавьдаг эсэх, жилийн эцэст үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	-	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1-д Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч" хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна, 2-т "Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт хүргүүлэх	хугацаа болоогүй
		Албан шаардлага: Гадаад паспортыг хэвлэх болон бэлдэц бэлтгэх үед үүссэн алдаа, үнэт цаасны дутагдлыг Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК, УБЕГ хэн нь хариуцах, хэрхэн нөхөн төлөх талаар албан ёсны шийдвэр гаргаагүй; Үнэт цаас болон гэрчилгээг худалдан авахдаа илүү, дутуу хэвлэхгүй байх, үлдэгдэл гарсан тохиодолд захиалагчийн хяналтад устгах талаар гэрээнд тусгаагүй байна.	-			
		Албан шаардлага: Төрийн үйлчилгээний албан тушаалын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан дүнгээс илүү олгож, нэмэгдсэн дүнгээр 13.123.210 төгрөгийн цалингийн зөрүүг бодож олгосон байна.	13,123,210.00	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т "Энэ хуулийн 10.1.2, 10.1.4-т заасан удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын төрөлд хамаарах албан тушаалын жагсаалтыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын цалингийн доод хэмжээг мөрдөх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.		

		Албан шаардлага: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөд нэмэлт өөрчлөлт оруулаагүй, нэмэлт гэрээ байгуулахгүйгээр гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэн шатахуун худалдан авсан байна.	21,170,000.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж батална" гэж заасныг зөрчсөн байна.		
		Албан шаардлага: Үндэсний дата төвөөс балансаас баланст шилжүүлэн авсан 11.868.000.00 төгрөгийн үнэ бүхий 138000 ширхэг ашиглалтаас гарсан ГҮЦ машины лавлагааны маягт бүртгэлгүй байна.	11,868,000.00	Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11-д "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, журам, заавар энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.		
		Албан шаардлага: Бараа материалын дансанд 15.885.4 мянган төгрөгийн үнийн дүнтэй 90 гр, 120гр, 75 гр-ийн 3 төрлийн нийт 25000 ширхэг хэрэгцээ шаардлагагүй хээтэй цаас нөөцөлсөн байна	15,885,427.28	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Санхүү, төсвийг зохистой удирдах, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.		

		Албан шаардлага: 1.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үйлдвэрийн үндсэн 2 ажилтныг томилж, тайланд онд Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуульд заасан хугацаанд хийгээгүй, хууль, дүрэм журамд нийцээгүй шийдвэр гаргаж, үр дүнгийн урамшуулал олгосон. 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн хурлаар 2023 оны цэвэр ашгийн 3,726,014,146.00 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр олгох, ногдол ашгийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн олгох, тус ногдол ашгаар Унгар улсад 938,906 еврогийн чиптэй гадаад паспортын бэлдцийн өр төлбөрийг бүрэн төлж, барагдуулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд хүргүүлэх шийдвэр гаргасан.	3,726,014,146.00	Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5."Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн", 75 дугаар зүйлийн 75.6-д "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно", 79 дүгээр зүйлийн 79.1.2-т "өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй" гэж заасныг зөрчсөн байна.	
--	--	--	------------------	--	--

		Албан шаардлага: Тайлант онд бизнес төлөвлөгөөг тухайн оны эхэнд төлөвлөж, хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлээгүй, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж батлуулахгүйгээр 5,968,460.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.	5,968,460,600.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-т "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал/цаашид "зорилтын санал" гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 24 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Сангийн ямаар зардлын дээд хязгаарыг батлуулна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.		
--	--	---	------------------	---	--	--

	Албан шаардлага: Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 24/03 дугаар тогтоолоор 160кв-ийн зөөврийн цахилгааны эх үүсвэрийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хягаарт заасныг зөрчин 141.725.1 мянган төгрөгийн барааг нээлттэй тендер шалгаруулалт зохин байгуулахгүйгээр харьцуулалтын арга ашиглан худалдан авсан байна.	141,725,100.00	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", 32 дугаар зүйлийн Нээлттэй тендер шалгаруулалтын арга 32.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч бараа, ажил үйлчилгээг худалдан авахад тендер шалгаруулалтын аргыг хэрэглэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Сангийн ямааар зардлын дээд хязгаарыг батлуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.		
--	--	----------------	--	--	--

10	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК	Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага: 1. 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2025.03.20-ны өдөр буюу Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас 4 хоног хоцроон ирүүлсэн байна. 2. Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1-1/141 дүгээр албан бичгээр ирүүлсэн нь Төрийн аудитын тухай хуульд заасан хугацаанаас 20 хоног хоцроон ирүүлсэн байна.	-	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 хуулийн 9-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ". 2. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ", мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", 42.2-т "Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан, энэ хуулийн 20.5-д заасан төлөвлөгөөг ирүүлээгүй нь тухайн албан хаагчийг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт хүргүүлэх	
----	--------------------------------	--	---	--	---	--

	Албан шаардлага: 1. "Бараа материалын хэвийн хорогдлын хэмжээ батлах тухай" Засгийн газрын 2019 оны 467 дугаар тогтоолын хавсралтад тусгагдаагүй буюу Төлөөлөн удирдах зөвлөл, Хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэр гаргаж, хэвийн болон хэвийн бус хорогдол тооцох норм, нормативыг баталж, дагаж мөрдөөгүй; 2. Устгалд оруулбал зохих материалын тоо, хэмжээ 2023 онд 20116 ширхэг байсан бөгөөд тус хорогдлыг устгасан комиссын шийдвэр, акт, дүгнэлт байхгүй; 3. 2024 онд 16687 ширхэг материалын хорогдол байгаа боловч тайлант онд багтааж, эрх бүхий комиссын хурлаар хэлэлцэж, шийдвэрлээгүй, тус хорогдол ямар шалтгаанаас үүссэн гэдгийг тодорхойлоогүй байгаа нь ашиглан, шамшигдал гарах мөн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийг бууруулах эрсдэлтэй байна.	-	Төрийн болон орон нутгийн өмчийн туха йхуулийн 73 дугаар зүйлийн 73.4-т" үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилээүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.		хугацаа болоогүй
--	---	---	--	--	------------------

		Албан шаардлага: Төрийн нууцад хамаарах худалдан авалтын жагсаалтад ороогүй үндсэн түүхий эд материалыг гэрээт компаниас 24.181.750.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, худалдан авсан байна.	24,181,750,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох", 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор тухайн хуулийн этгээдийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх талаарх санал /цаашид зорилтын санал гэх/-ын төслийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 13 дэх хэсгийн 11-т "Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд заасан нууц болон холбогдох бусад хуульд заасан хаалттай, хязгаарлалттай мэдээлэл агуулаагүй төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр", мөн хэсгийн 12-т "байгууллагын нууцад хамааруулсан мэдээллийн жагсаалт", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан вахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна	
11		Албан шаардлага: Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 3.172.284.8 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүсгэж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	3,172,284,849.04	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.	

	Улсын бүртгэлийн ерөнхий газар/нэгтгэл/	Албан шаардлага: Аудитаар бараа материалын тооллого хийхэд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК-д хүлээлгэн өгсөн, цахим гадаад паспортын 1664 ширхэг 113.680.00 мянган төгрөгийн бэлдэц бодитоор оршин байхгүй байна.	113,680,000.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодох гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ. Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн хуулийн байгууллагад шилжүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1-т "Ажилтан дараах тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлага хүлээнэ", 131.1.2-т "эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулсан, эсхүл хөдөлмөрийн гэрээнд энэ тухай тусгайлан тохирсон ажилтан ажил үүргээ гүйцэтгэх үедээ ажил олгогчид хохирол учруулсан", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.	Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хүргүүлэх	
--	---	---	----------------	--	--	--

		Албан шаардлага: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 27.906.593.6 мянган төгрөгийн 43 зөрчил илэрсэн нь харьяа байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйтэй холбоотой байна.	-	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна" гэж заасантай нийцэхгүй байна.		
12	Нийт дүн		34,365,081,183.28			

УБЕГ-ын 2024 оны санхүүгийн тайланд Үндэсний болон Төрийн Аудитын газраас тавьсан зөвлөмжийн биелэлт

2025.06.12-ны байдлаар

№	Байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Хууль эрх зүйн үндэслэл	Зөвлөмжийн биелэлтийг хэзээ, хаана өгөх	Биелэлт
1	Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Төлбөр тооцоог урьдчилан хянаж баталгаажуулаагүйгээс шалтгаалан нийгмийн даатгалын 1.876.480.00 төгрөгийг авлага үүссэн байна.	1,876,480.00	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх. "НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалттай нийцэхгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Албан шаардлагын биелэлтийг Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 14/392 тоот албан бичгээр Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

2	Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 166.548.7 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй.	-	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3 дугаар зүйлийн 3.2.10 заалттай нийцэхгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.29-ний өдрийн 16/200 тоот албан бичгээр Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн
3	Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Тус байгууллага нь албан хаагчдын 2024 оны ээлжийн амралтын хуваарийг гаргаагүй, ээлжийн амралт олгох мэдэгдлээр албан хаагчдыг амраасан байна.	-	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2-т "Ажил олгогч нь тухайн ажлын жилийн ээлжийн амралтын хуваарийг ажилтны саналыг үндэслэн ажил, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байдлаар зохион байгуулж, жил бүрийн нэгдүгээр улиралд батална", 1.3-д "Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2022 оны 10 дугаар сарын 13-ны А/1300 тоот тушаалаар баталсан Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.3-т "зохион байгуулалтын нэгжийн албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг байгууллагын дарга, орон нутгийн газар, хэлтсийн албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг тухайн нэгжийн дарга тухай жил бүрийн нэгдүгээр сард батална" гэж заасныг зөрчсөн байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 22/826 тоот албан бичгээр Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.

		Зөвлөмж: Байгууллагын нягтлан бодогчийн эзэлжийн амралт олгох мэдэгдлийг 2024 оны 1 дүгээр сарын 30-аас 2 дугаар сарын 21-ны хооронд ажлын 20 хоног амрахаар олгосон байхад нягтлан бодогч 2.3.4.6.8 дугаар саруудад 1-5 хоногоор хэсэгчлэн амарсан байна.	-	Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-т "Ажилтан өөрийн хүсэлтээр эзэлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах эзэлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын шргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна" гэж заасныг зөрсөн байна.		
4	Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Тайлант онд нягтлан бодогчид 1.471.000.00 төгрөгийн балансын урамшууллыг, үр дүнгийн урамшуулалттай давхардуулан олгосон байна.	-		Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.03.25-ны өдрийн 24/199 тоот албан бичгээр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
		Зөвлөмж: Тайлант онд үйл ажиллагааны орлогыг 260.000.000 төгрөгөөр төлөвлөсний 3 хувь болох 7.800.000 төгрөгийг ахмадын санд төлөвлөсөн эсэх нь нотлогдоогүй байхад оны эцсийн үлдэгдэл 14.203.726.13 төгрөгийг Ахмадын санд төвлөрүүлсэн байна.	-			
		Зөвлөмж: 1-12 дугаар сард гэрээ хэлцэл байгуулах, захиргааны шийдвэр гаргах, хөрөнгө зарцуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хөтөлж шилэн дансанд байршуулаагүй байна.	-	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэж заасантай нийцэхгүй байна.	Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллахыг зөвлөж байна.	

5	Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, үлдэх өрөтөггүй болсон 236 ширхэг үндсэн хөрөнгийг дахин үнэлж данс бүртгэлд тусгаагүй байна.	-	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.06.02-ны өдрийн 27/641 тоот албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
		Зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалингийн зөрүүг тооцож олгохдоо нэмэгдлүүдийг тооцохгүй зөвхөн үндсэн цалингийн зөрүүг тооцож олгосон байна.	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гархаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.		
		Зөвлөмж: Албан хаагчдын цалингаас суутгасан ХХОАТ-ын зөрүүг тохируулаагүй, тохируулгын тайланг хийгээгүй байна.	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гархаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.		
		Зөвлөмж: УБЕГ-ын даргын 2019 оны Б/178 дугаар тушаалаар гэрээт албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 3-аар баталсан байхад орон тоог хэтрүүлэн 5-аар ажиллуулсан байна.	-	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.		
6	Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэргүй олгосон.	13,463,296.00	Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно". Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 09-ний дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	хугацаа болоогүй

7	Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс	Зөвлөмж: Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.		Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр Ахмадын сан байгуулах бөгөөд "Ахмадын сан" байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2025.05.30-ны өдрийн 30/736 тоот албан бичгээр Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлсэн.
8	Нийслэлийн Улсын бүртгэлийн газар	Зөвлөмж: НУБГ бичиг хэрэг, аж ахуй хангамжийн материал худалдан авах гэрээнд бараа материалын тоо ширхэг үнийг тусгаагүй.	28,150,000.00	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлагыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", 54 дүгээр зүйлийн 54.8-д "Захиалагч энэ хуульд зааснаар хүргүүлэх урилгыг тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, цахим системд бүртгүүлсэн аж ахуй эрхлэгчид нэгэн зэрэг илгээнэ" гэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлэх	Зөвлөмжийн биелэлтийг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын 2025.04.30-ны өдрийн 10/259 тоот албан бичгээр Ниямазон аудит ХХК-д хүргүүлсэн.
	Улсын бүртгэлийн ерөнхий газар/төв аппарат/	Зөвлөмж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны А/706 тушаалаар баталсан "Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортын бэлдцийг хүлээн авах, олгох, зарцуулалтад тавих журам"-ыг шинэчлэн батлаагүй байна.	-	Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т "улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг энэ хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх" гэж заасантай нийцэхгүй байна.		

9		Зөвлөмж: Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа "Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журам"-ыг 2018 оноос хойш батлаагүй байгаагаас төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгээгүй байна.	-	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9-д "Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална" гэж заасантай нийцэхгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх	хугацаа болоогүй
		Зөвлөмж: Койск машин буюу Голомт банкны /48-тай/ дансанд төвлөрсөн орлого, торгууль, улсын тэмдэгтийн хураамжийг ангилж, бүртгэх програмын хөгжүүлэлт хийгээгүйгээс тус дансанд төвлөрсөн орлогыг мерчант буюу бөөн дүнгээр татаж байгаа нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг зөрүүтэй тайлагнах эрсдэлтэй байна.	-	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага,хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.		
		Зөвлөмж: Төсвийн төвлөрүүлэн болон шууд захирагчийн санхүүгийн тайланд өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 1/4624 дүгээр албан бичгээр хамтатган ҮАГ-г ирүүлсэн байна.	-	Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2.-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.		

	Зөвлөмж: Бараа материалын дансанд 897.752.0 мянган төгрөгийн 30000 ширхэг үйлдвэрийн алдаатай дахин ашиглах боломжгүй цахим гадаад паспорт бэлдэц бүртгэлтэй байна.		Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 10 дугаар зүйлийн 10.1.11-д "төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж, улсын төсвийн байгууллагаас нийлүүлэх арга хэмжээний чанарын шаардлагыг хангуулах" тус тус нийцэхгүй байна.		
	Зөвлөмж: Дансны ангилал зөрчин тээвэр шатахууны зардлаас бичиг хэргийн зардалд 1.479.5 мянган төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлтийн төлбөрт 304.3 мянган төгрөг, цэвэрлэгээний материал худалдан авх зардалд 1.541.9 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.	3,325,700.00	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал" гэж заасныг зөрчсөн байна.		
	Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг зөрчсөн байна.		

10	Төрийн үнэт цаас хэвлэл ТӨДХХК	Зөвлөмж: ТУЗ-ийн хурал хийж дүгнэлт ирүүлээгүй байхад ХЭХ-ыг хийж, хүчин төгөлдөр бус дараах шийдвэрүүдийг гаргасан байна. Үүнд: Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 24/01 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар баталж, бүтэц орон тооны дээд хязгаарыг захиргаа, удирдлагын алба 12, Үйлдвэрийн алба 35, санхүү аж ахуйн алба 11, нийт 58 орон тоотой баталсан боловч гүйцэтгэлээр захиргаа, удирдлагын алба 13, Үйлдвэрийн алба 29, Санхүү аж ахуйн алба 9, ТУЗ-ийн гишүүн 7 хийт 58 хүний бүрэлдхүүнтэй ажилласан нь үндсэн үйлдвэрийн ажилчдын орон тоо дутуу, удирдах албан тушаалтны орон тоо хэтрэх эрсдэлтэй байна.	-	Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5."Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно" гэж заасантай нийцэхгүй байна.	Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх	хугацаа болоогүй
11	Нийт дүн		46,815,476.00			

Нэгтгэсэн: Нягтлан бодол



А Наранцэцэг